

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ГЕГ-ын харьяа Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/177-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ГЕГ-ЫН ХАРЬЯА СЭЛЭНГЭ АЙМАГ
ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ӨНӨБОЛД ТАНАА

2024.02.19 № САН-2024/177-НА-СТА-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ГЕГ-ын харьяа Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосноос голлон шалтгаалж тус газрын 2023 оны нийт зардал өмнөх оноос 36.2 хувиар нэмэгдсэн байна.

ГЕГ-ын даргын 2023 оны А/703 дугаар тушаалын дагуу 5,730,954.4 мянган төгрөгийн өртөгтэй Сүхбаатар хилийн боомтын нэг цэгийн үйлчилгээний цогцолборын 14 нэрийн барилга, байгууламжийг ашиглалтад хүлээн авч балансад бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

ГЕГ-ын даргын 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/272 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль

018020024

тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ч 2021 онд батлагдсан “Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-иар хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх чиг үүрэг гаалийн байгууллагад шилжиж, 2022 оноос тус газарт Сүхбаатар боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албыг нэгтгэсэнтэй холбоотой өөрчлөлтийг тусгаагүй байна.

Ковид 19 цар тахал өвчинтэй холбоотойгоор өмнөх онуудад эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлаас ажилчдын дархлаажуулалтын зардал гаргаж байсан ба тайлант онд / цар тахал өвчлөл гараагүй / уг зардалд 13,959.8 мянган төгрөг зарцуулсан нь төсөв зориулалт бусаар зарцуулагдах эрсдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газар нь тайлант онд “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд 61 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 86.0 хувиар дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	452,170,265.06	555,039,403.60
33	АВЛАГА	24,605.00	0.00
33500	Бусад авлага	24,605.00	0.00
33510	Байгууллагаас авах авлага	24,605.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	452,145,660.06	555,039,403.60
35100	Түүхий эд материал	84,339,573.46	228,661,751.40
35110	Тусгай зориулалттай материал	80,028,827.46	186,588,181.40
35130	Эм боох материал	4,310,746.00	42,073,570.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,585,975.20	11,514,396.80
35400	Хангамжийн материал	364,220,111.40	314,863,255.40
35410	Бичиг хэргийн материал	7,875,210.00	8,018,750.00
35420	Түлш, шатах тослох материал	23,175,360.00	18,725,320.00
35430	Аж ахуйн материал		3,077,000.00
35440	Сэлбэг хэрэгсэл		18,725,320.00
35470	Бусад хангамжийн материал	333,169,541.40	213,207,449.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,588,010,678.42	15,134,175,468.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,588,010,678.42	15,134,175,468.69
39200	Биет хөрөнгө	5,588,702,366.92	12,134,511,532.19
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,003,619,134.38	10,328,739,723.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	-717,801,553.48	-905,863,224.85
39203	Авто-тээврийн хэрэгсэл	514,212,170.00	514,212,170.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-314,198,636.92	-370,275,107.56
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	12,687,573,318.80	13,814,507,499.47
39206	Хуримтлагдсан элэгдэл	-12,091,093,489.32	-11,791,264,277.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	197,845,072.50	244,086,346.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-90,158,772.15	-77,154,511.07
39214	Бусад үндсэн хөрөнгө	479,734,845.91	471,873,414.41
39215	Хуримтлагдсан элэгдэл	-82,844,360.52	-96,165,137.86
39217	Ном	1,814,637.72	1,814,637.72
39300	Биет бус хөрөнгө	2,999,308,311.50	2,999,663,936.50
39301	Программ хангамж	97,665,472.99	96,646,447.62
39302	Хуримтлагдсан элэгдэл	-82,077,100.49	-80,702,450.12
39303	Бусад биет бус хөрөнгө	2,983,719,939.00	2,983,719,939.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,040,180,943.48	15,689,214,872.29
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,994,309.30	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,994,309.30	0.00
41300	Өглөг	4,994,309.30	0.00
41360	Бусад өглөг	4,994,309.30	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	4,994,309.30	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,035,186,634.18	15,689,214,872.29
51	Засгийн газрын хувь оролцоо	9,035,186,634.18	15,689,214,872.29
51100	Засгийн газрын оруулсан капитал	10,545,993,603.22	10,545,993,603.22
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	10,545,993,603.22	10,545,993,603.22
51200	Хуримтлагдсан үр дүн	-2,532,613,583.15	4,121,414,654.96
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,149,669,875.07	-2,532,613,583.15
51220	Тайлант үеийн үр дүн	-1,382,943,708.08	6,654,028,238.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,021,806,614.11	1,021,806,614.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,040,180,943.48	15,689,214,872.29

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,215,376,416.32	14,144,670,462.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	837,873,416.32	7,185,475,898.34
120	Нийтлэг татварын бус орлого	837,873,416.32	7,185,475,898.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,101,700.00	23,273,819.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,101,700.00	21,944,819.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	522,757,011.54	7,019,193,213.34
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	305,014,704.78	144,337,866.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,377,503,000.00	6,959,194,564.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,377,503,000.00	6,959,194,564.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,377,503,000.00	6,959,194,564.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,447,844,290.26	7,490,642,224.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,447,844,290.26	7,490,642,224.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,508,923,483.83	6,339,378,712.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,038,038,036.00	4,183,197,038.26
210101	Үндсэн цалин	1,647,903,902.00	2,216,871,058.26
210102	Нэмэгдэл	832,918,681.00	1,263,629,275.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	247,214,500.00	241,696,000.00
210104	Урамшуулал	310,000,953.00	461,000,705.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	391,783,201.45	542,939,754.21
210201	Тэтгэврийн даатгал	269,715,405.55	374,298,600.99
210202	Тэтгэмжийн даатгал	31,233,178.98	43,304,251.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,240,622.19	33,364,813.46
210204	Ажилгүйдлийн даатгал	5,938,216.41	8,228,099.08
210205	Эрүүл мэндийн даатгал	60,655,778.32	83,743,989.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	189,430,547.24	338,637,103.79
210301	Гэрэл, цахилгаан	58,979,694.24	158,923,618.79
210302	Түлш, халаалт	118,410,685.19	156,612,904.00
210303	Цэвэр, бохир ус	12,040,167.81	23,100,581.00
2104	Хангамж, бараа материалын зардал	138,354,059.43	119,346,436.21
210401	Бичиг хэрэг	21,834,740.46	21,961,540.00
210402	Тээвэр, шатахуун	29,885,416.91	38,314,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,766,655.12	4,537,442.26
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	786,000.00	5,277,253.95
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	68,226,293.34	49,026,200.00
210408	Бараа материал акталсны зардал	8,854,953.60	230,000.00
2105	Нормативт зардал	47,226,140.71	109,345,575.06
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	36,004,140.71	103,140,575.06
210502	Хоол, хүнс	1,822,000.00	6,205,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,400,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	284,830,998.76	275,870,406.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,509,350.00	1,836,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	164,281,238.76	72,693,776.00
210604	Урсгал засвар	113,040,410.00	201,340,630.00
2107	Томилолт, зочны зардал	1,400,800.00	1,306,000.00
210702	Дотоод албан томилолт	1,400,800.00	1,306,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	139,135,008.30	198,264,325.91
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,684,631.50	123,617,776.51
210803	Даатгалын үйлчилгээ	2,653,137.00	2,699,837.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	569,585.00	510,925.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	286,000.00	242,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,486,750.00	8,603,800.00
210807	Газрын төлбөр	68,213.00	103,349.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	59,386,691.80	62,486,638.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,278,724,691.94	570,472,073.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	2,581,460.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,278,724,691.94	567,890,613.07
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	938,920,806.43	1,151,263,511.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,600,000.00	240,068,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,600,000.00	240,068,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	932,320,806.43	911,195,511.72
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	932,320,806.43	911,195,511.72
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-232,467,873.94	6,654,028,238.11
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,150,475,834.14	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	1,149,204,874.14	0.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	1,270,960.00	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,382,943,708.08	6,654,028,238.11

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,417,032,400.00	6,981,139,383.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,077,095.00	21,944,819.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,077,095.00	21,944,819.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,077,095.00	21,944,819.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,077,095.00	21,944,819.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,406,955,305.00	6,959,194,564.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,377,503,000.00	6,959,194,564.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,377,503,000.00	6,959,194,564.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	29,452,305.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,452,305.00	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,220,066,850.00	6,886,277,193.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,220,066,850.00	6,886,277,193.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,281,146,043.57	5,735,013,681.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,038,026,036.00	4,183,172,433.26
210101	Үндсэн цалин	1,647,891,902.00	2,216,846,453.26
210102	Нэмэгдэл	832,918,681.00	1,263,629,275.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	247,214,500.00	241,696,000.00
210104	Урамшуулал	310,000,953.00	461,000,705.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	391,466,088.01	542,939,754.21
210201	Тэтгэврийн даатгал	269,398,292.11	374,298,600.99

210202	Тэтгэмжийн даатгал	31,233,178.98	43,304,251.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,240,622.19	33,364,813.46
210204	Ажилгүйдлийн даатгал	5,938,216.41	8,228,099.08
210205	Эрүүл мэндийн даатгал	60,655,778.32	83,743,989.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	191,024,957.24	335,172,063.79
210301	Гэрэл, цахилгаан	58,979,694.24	158,923,618.79
210302	Түлш, халаалт	118,285,095.19	155,002,864.00
210303	Цэвэр, бохир ус	13,760,167.81	21,245,581.00
2104	Хангамж, бараа материалын зардал	194,359,155.12	125,768,283.21
210401	Бичиг хэрэг	15,682,950.00	22,318,940.00
210402	Тээвэр, шатахуун	26,390,000.00	36,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,766,655.12	4,537,442.26
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	786,000.00	5,277,253.95
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	142,733,550.00	57,634,647.00
2105	Нормативт зардал	100,254,735.00	93,697,060.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	88,342,735.00	87,492,060.00
210502	Хоол, хүнс	1,822,000.00	6,205,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,090,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	217,360,150.70	266,225,939.30
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,437,350.00	37,511,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	91,876,700.00	22,380,000.00
210604	Урсгал засвар	108,046,100.70	206,334,939.30
2107	Томилолт, зочны зардал	1,400,800.00	1,306,000.00
210702	Дотоод албан томилолт	1,400,800.00	1,306,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	127,035,951.50	184,150,687.51
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,684,631.50	123,617,776.51
210803	Даатгалын үйлчилгээ	2,653,137.00	2,699,837.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	569,585.00	510,925.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	286,000.00	242,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,077,385.00	9,018,800.00
210807	Газрын төлбөр	68,213.00	103,349.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	38,697,000.00	47,958,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,218,170.00	2,581,460.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,218,170.00	2,581,460.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	938,920,806.43	1,151,263,511.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,600,000.00	240,068,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,600,000.00	240,068,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	932,320,806.43	911,195,511.72
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	932,320,806.43	911,195,511.72
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	196,965,550.00	94,862,190.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	196,965,550.00	94,862,190.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	196,965,550.00	94,862,190.00
2200	Дотоод эх үүсвэрээр	196,965,550.00	94,862,190.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	196,965,550.00	94,862,190.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-196,965,550.00	-94,862,190.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,630,915,603.22	1,158,621,288.41	-1,284,903,295.09	8,504,633,596.54
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	135,233,420.02	135,233,420.02
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,630,915,603.22	1,158,621,288.41	-1,149,669,875.07	8,639,867,016.56
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-136,814,674.30	0.00	-136,814,674.30
7	Өмчид гарсан өөрчлөлт	1,915,078,000.00	0.00	0.00	1,915,078,000.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-1,382,943,708.08	-1,382,943,708.08
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,545,993,603.22	1,021,806,614.11	-2,532,613,583.15	9,035,186,634.18
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	10,545,993,603.22	1,021,806,614.11	-2,532,613,583.15	9,035,186,634.18
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,545,993,603.22	1,021,806,614.11	-2,532,613,583.15	9,035,186,634.18
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	6,654,028,238.11	6,654,028,238.11
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,545,993,603.22	1,021,806,614.11	4,121,414,654.96	15,689,214,872.29

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,981,501,800.00	6,069,943,871.28	-911,557,928.72	86.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,981,501,800.00	6,069,943,871.28	-911,557,928.72	86.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,708,051,800.00	5,829,875,871.28	-878,175,928.72	86.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,875,202,000.00	4,183,172,433.26	-692,029,566.74	85.81
210101	Үндсэн цалин	2,240,853,200.00	2,216,846,453.26	-24,006,746.74	98.93
210102	Нэмэгдэл	1,794,156,800.00	1,263,629,275.00	-530,527,525.00	70.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	364,992,000.00	241,696,000.00	-123,296,000.00	66.22
210104	Урамшуулал	475,200,000.00	461,000,705.00	-14,199,295.00	97.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	609,400,300.00	542,939,754.21	-66,460,545.79	89.09
210201	Тэтгэврийн даатгал	426,224,800.00	374,298,600.99	-51,926,199.01	87.82
210202	Тэтгэмжийн даатгал	44,470,000.00	43,304,251.01	-1,165,748.99	97.38

210203	ҮОМШӨ-ний даатгал	34,254,000.00	33,364,813.46	-889,186.54	97.40
210204	Ажилгүйдлийн даатгал	8,274,000.00	8,228,099.08	-45,900.92	99.45
210205	Эрүүл мэндийн даатгал	96,177,500.00	83,743,989.67	-12,433,510.33	87.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	370,000,000.00	335,172,063.79	-34,827,936.21	90.59
210301	Гэрэл, цахилгаан	180,000,000.00	158,923,618.79	-21,076,381.21	88.29
210302	Түлш, халаалт	168,000,000.00	155,002,864.00	-12,997,136.00	92.26
210303	Цэвэр, бохир ус	22,000,000.00	21,245,581.00	-754,419.00	96.57
2104	Хангамж, бараа материалын зардал	134,500,000.00	125,768,283.21	-8,731,716.79	93.51
210401	Бичиг хэрэг	22,600,000.00	22,318,940.00	-281,060.00	98.76
210402	Тээвэр, шатахуун	36,000,000.00	36,000,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,400,000.00	4,537,442.26	-6,862,557.74	39.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,300,000.00	5,277,253.95	-1,022,746.05	83.77
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	58,200,000.00	57,634,647.00	-565,353.00	99.03
2105	Нормативт зардал	98,100,000.00	93,697,060.00	-4,402,940.00	95.51
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	91,800,000.00	87,492,060.00	-4,307,940.00	95.31
210502	Хоол, хүнс	6,300,000.00	6,205,000.00	-95,000.00	98.49
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	411,000,000.00	359,988,129.30	-51,011,870.70	87.59
210601	Багаж, техник, хэрэгсэл	122,200,000.00	118,410,390.00	-3,789,610.00	96.90
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	23,800,000.00	22,380,000.00	-1,420,000.00	94.03
210604	Урсгал засвар	265,000,000.00	219,197,739.30	-45,802,260.70	82.72
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	1,306,000.00	-194,000.00	87.07
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,306,000.00	-194,000.00	87.07
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	205,249,500.00	185,250,687.51	-19,998,812.49	90.26
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	136,050,000.00	123,617,776.51	-12,432,223.49	90.86
210803	Даатгалын үйлчилгээ	2,700,000.00	2,699,837.00	-163.00	99.99
210804	Тээврийн хэрэгслийн татвар	794,500.00	510,925.00	-283,575.00	64.31
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	295,000.00	242,000.00	-53,000.00	82.03
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,300,000.00	10,118,800.00	-7,181,200.00	58.49
210807	Газрын төлбөр	110,000.00	103,349.00	-6,651.00	93.95
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	48,000,000.00	47,958,000.00	-42,000.00	99.91
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,100,000.00	2,581,460.00	-518,540.00	83.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,100,000.00	2,581,460.00	-518,540.00	83.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	273,450,000.00	240,068,000.00	-33,382,000.00	87.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	273,450,000.00	240,068,000.00	-33,382,000.00	87.79
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	273,450,000.00	240,068,000.00	-33,382,000.00	87.79

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,981,501,800.00	6,069,943,871.28	-911,557,928.72	86.94
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,961,501,800.00	6,047,999,052.28	-913,502,747.72	86.88
310001	Улсын төсвөөс санхүүжих	6,961,501,800.00	6,047,999,052.28	-913,502,747.72	86.88
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	20,000,000.00	21,944,819.00	1,944,819.00	109.72
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	21,944,819.00	1,944,819.00	109.72

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

ГЕГ-ын харьяа Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газар / цаашид Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газар гэх/ нь “Мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэхжүүлэх замаар үндэсний аюулгүй байдлыг хангаж, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дэмжинэ” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих,
- Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөнд хяналт тавих,
- Гаалийн бүрдүүлэлт хийж гаалийн болон бусад татвар, хураамжийг ногдуулах, хураах, албадан хураах, тэдгээрт хяналт тавих,
- Гаалийн мэдээллийн системийг боловсронгуй болгох, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, хамгаалах,
- Гадаад худалдааны гаалийн статистикийн мэдээлэл гаргах,
- Гаалийн хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, мэдээллээр хангах,
- Гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хуульд заасан хариуцлага хүлээлгэх,
- Гаалийн байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх,
- Гаалийн тухай хуульд заасны дагуу оюуны өмчийн эрхийг хамгаалах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Гаалийн тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06-нд, 2023 оны 07 дугаар сарын 07, 11-р сарын 10-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн зарим албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд ГЕГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хэрэгжүүлж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг **аккруэл** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ГЕГ-ын даргын 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/272 дугаар тушаалаар ГЕГ болон түүний харьяа байгууллагуудын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн боловч 2022 оноос тус газарт Сүхбаатар боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албыг нэгтгэсэнтэй холбоотой өөрчлөлтийг тусгаагүй байна.


3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,649,034.4 мянган төгрөгөөр буюу 73.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт



Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	24.60	0.00	-24.60
Урьдчилгаа	0.00	0.00	0.00
Бараа материал	452,145.60	555,039.40	102,893.80
Үндсэн хөрөнгө	8,588,010.70	15,134,175.50	6,546,164.80
Нийт хөрөнгө	9,040,180.90	15,689,214.90	6,649,034.00
Өр төлбөр	4,994.30		-4,994.30
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	9,035,186.60	15,689,214.90	6,654,028.30
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,040,180.90	15,689,214.90	6,649,034.00

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

Бараа материалын дансны үлдэгдэл 555,039.4 мянган төгрөг болж 102,893.8 мянган төгрөгөөр өссөн нь дараах хүчин зүйлүүдээс шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 567,129.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан,
- ГЕГ-аас 143,008.9 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авсан,
- Шатахууны урамшуулалд 1,329.0 мянган төгрөгийн шатахууны талон хүлээн авсан,
- ГЕГ-т 20,418.5 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн,
- Үйл ажиллагаанд 588,154.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан гэх мэт.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 15,134,175.5 мянган төгрөг болж 6,546,164.8 мянган төгрөгөөр өссөн нь ГЕГ-ын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/703 дугаар тушаалаар Нэг цэгийн үйлчилгээний 6 давхар барилгын 5,073,172.8 мянган төгрөгийн барилга байгууламж, 522,800.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлэн авсан зэргээс голлон шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,789,338.9 мянган төгрөг, нийт зарлагыг 6,789,338.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас дараах байдлаар өөрчлөн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 1,289,856.5 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 173,832.0 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 315,770.2 мянган төгрөгөөр,
- Хангамж бараа материалын зардлыг 103,812.7 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 53,545.0 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 241,286.5 мянган төгрөгөөр,
- Томилолт, зочны зардлыг 13,500.0 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 227,007.9 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 2,556.0 мянган төгрөгөөр,
- Бусад урсгал шилжүүлгийн зардлыг 34,129.3 мянган төгрөгөөр зэрэг **2,455,296.1** мянган төгрөгөөр бууруулж, нийт **4,334,042.8** мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг 2,647,459.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн /цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 1,562,200.0 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 195,275.0 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 61,300.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 384,800.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 151,834.0 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 266,850.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна/ нийт 6,981,501.8 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Улсын төсвөөс 6,961,501.8 мянган төгрөг,
- Туслах үйл ажиллагааны орлогоос 20,000.0 мянган төгрөг гэх мэт.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлээр төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 6,961,501.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 20,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр улсын төсвөөс 6,659,194.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоор 21,994.8 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,069,943.8 мянган төгрөг буюу 86.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 871,119.5 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	6,594,591.8	5,723,472.3	871,119.5	86.8

2	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	3,000.0	2,940.0	60.0	98.0
3	Мэдээлэл, сурталчилгааны зардал	660.0	660.0	0.0	100.0
4	Харуул, хамгаалалтын зардал	91,800.0	87,110.8	4,689.2	94.9
5	Шүүхийн шийдвэрийн дагуу олгох	18,000.0	15,692.7	2,307.3	87.2
6	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	273,450.0	240,068.0	33,382.0	87.8
	Дүн	6,981,501.8	6,069,943.8	911,558.0	86.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130435402 тоот дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/				
№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам / Тендер шалгаруулалтын арга
1	Харуул хамгаалалт	91,800.0	91,341.0	НТШ
2	Эм бэлдмэл	80,000.0	54,814.0	НТШ
3	Түлш халаалт	70,000.0	69,940.0	Харьцуулалтын арга
4	Шатахуун, шатах тослох материал	36,000.0	36,000.0	Харьцуулалтын арга
	Нийт дүн	277,800.0	252,095.0	

Харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх тендерт Шүрэн-Үндэс ХХК, шил сав, туслах материал нийлүүлэх тендерт Радон-Энх ХХК, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх тендерт Монбиофарм ХХК, нүүрс нийлүүлэх тендерт Экопартнерс ХХК, шатахуун, шатах тослох материал нийлүүлэх тендерт НИК ХХК тус тус шалгарч, гэрээ байгуулан ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн үндсэн бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/53 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 6,447,844.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 64,478.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж дүгнэсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт


“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газар нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Албан бичгийн төслийг зайлшгүй шаардлагатай тохиолдолд хэвлэж, албан хаагчидтай албаны цахим шуудангаар харьцаж бичгийн цаасны хэрэглээг бууруулсан,
- Хэвлэл захиалга хийгээгүй,
- Баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, байгууллагын ойг тэмдэглэх зэргийг зохион байгуулаагүй,
- Зочин, төлөөлөгч хүлээн авах, үдэх, бэлэг дурсгалын зүйлсэд зардал гаргаагүй,
- Суурин утасны хэрэглээг бууруулсан,
- Албан хэрэг хөтлөлтийн e-doc систем ашиглаж бичиг хэргийн зардлыг бууруулсан,

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.



4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар нь мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллээс 167 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

Хугацаа хоцроосон:

- Дараа жилийн төсвийн төслийг 1 удаа,
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалтыг 1 удаа,
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг 2 удаа.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөж, шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмж өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	49,510.4	1	49,510.4	100.0
Зөвлөмж	2	2,528.6	2	2,528.6	100.0
Нийт дүн	3	52,039.0	3	52,039.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **1,329.0** мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын 1,329.0 мянган төгрөгийн орлогыг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн,

Аудитаар илэрсэн зөрчлийг² арилгах зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Агуулахаас тавьж олгосон бөгөөд шууд зардлаар бүртгэх бараа материалыг үлдэгдлээр бүртгэсэн бөгөөд үндсэн хөрөнгийн шинж чанартай 16 нэр төрлийн хөрөнгийг бараа материалд бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (б)-д “Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын Бараа материал: “Бараа материалыг ажил үйлчилгээнд ашиглахаар тавьж олгоход: Дт. Зардал /Зардлын зүйлээр/, Кт. Хангамжийн материалын холбогдох дэд данс” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн ангилал, бүртгэлийг холбогдох стандарт, журмын дагуу үнэн зөв хийж, 2024 оны эхний хагас жилийн тайланд залруулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		Зөвлөмж 4317143998 Тоо 35 905 Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	
Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн	1	1,329.0					1	1,329.0	
Дүн	1	1,329.0					1	1,329.0	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Үүнээс						Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Хөрөнгийн ангилал, бүртгэлийг буруу гүйцэтгэсэн	1						
Дүн	1						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Үүнээс						Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	

